



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 272


Улаанбаатар хот

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний
төвийн талаар авах зарим арга
хэмжээний тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 15.16 дугаар зүйл, Засгийн газрын тухай хуулийн 24.1.4 заалт, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 231 тоот тогтоолыг үндэслэн тушаах нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн орон тооны дээд хязгаарыг 203 орон тоогоор баталж, тус төвийн үлгэрчилсэн бүтцийг нэгдүгээр хавсралтаар, балансаас балансад шилжиж байгаа хөрөнгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эрүүл мэндийн газрын (хуучин нэрээр) бүтцэд байсан 18 орон тоог Эрүүл мэндийн яамнаас, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд төсөв, хөрөнгийн хамт шилжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.
3. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу балансаас балансад шилжиж байгаа төсөв, хөрөнгийг хүлээн авч, өөрийн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө. Ганчимэг)-д үүрэг болгосугай.
4. Үлгэрчилсэн бүтцийн дагуу өөрийн байгууллагын бүтэц, дүрмээ батлуулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг)-д үүрэг болгосугай.
5. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилтийн төсвийг 2014 оноос эхлэн үе шаттайгаар жил бүр төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д. Мөнхбат)-т даалгасугай.
6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 249 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
7. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

САЙД



Н. УДВАЛ

002261

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 сарын 26 өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Төвийн захирал

Эрдмийн зөвлөл

Захиргаа, аж ахуйн алба

Нийгмийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн дэд захирал

Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан дэд захирал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

Биотехнологийн судалгаа, үйлдвэр, инноваци, инкубатор

НЭМ-ийн лавлагаа лаборатори

Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, технологийн алба

Эрүүл мэндийн дэмжих алба

Хор судлал, хордлогын тандалтын алба

Орчны эрүүл мэндийн тандалтын алба

Хоол судлалын алба

ХБӨ тандалт сэргийлэлтийн алба

Нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн алба

88

АЛБАДЫН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

Нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн алба

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах

- Нийгмийн эрүүл мэндийн талаар хэрэгжүүлэх хөтөлбөр, стратеги, стандарт болон дагалдан гарах баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах үндэслэл, бодлогын санал, зөвлөмж боловсруулах
- Үндэсний түвшинд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулах, тайлагнах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бусад салбар, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах, хамтын ажиллагааг уялдуулах, зохицуулах;

Халдварт бус өвчний тандалт сэргийлэлтийн алба

Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр ханган, халдварт бус өвчний тандалтын тогтолцоог бүрдүүлж, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах

- Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх хянах, эрт илрүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, тайланг нэгтгэх;
- Зонхилон тохиолдох халдварт бус өвчин түүний эрсдэлт хүчин зүйлийн нөлөөг судлах тархвар зүйн судалгааг зохион байгуулах, оролцох;
- Халдварт бус өвчний чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн тайланг нэгтгэх;
- Халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Осол гэмтэл, хүчирхийллийн чиглэлээр тандалт судалгаа, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, иргэний нийгэм, бусад салбарын оролцоог хангах, осол гэмтэл, хүчирхийллийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Архи, тамхи, мансууруулах болон бусад сэтгэц нөлөөт бодист донтох эмгэгийн тандалт судалгаа, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээний санг ажиллуулах, энэ чиглэлээр салбарын болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэний болон олон нийтийн байгууллагуудын оролцоог хангах;

- Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр тандалт судалгаа хийх үйл ажиллагааг зохион байгуулах, энэ чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Бага насны хүүхэд, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эцэг, эхчүүдэд амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Эрүүл мэнд, хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, бусад салбартай хамтран ажиллах;
- Эмийн зохистой хэрэглээний талаархи сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

Хоол судлалын алба

Хүн амын хоол тэжээл, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хоол тэжээлээс шалтгаалсан эмгэгээс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулах

- Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тандалт судалгаа хийхэд оролцох, холбогдох байгууллагыг хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэдээний сан ажиллуулах, хүнсний аюулгүй байдлын байгууллагуудын олон улсын сүлжээний Монгол дахь онцгой байдлын үеийн холбоо тогтоох ажлын хэсэг (INFOSAN) болон Монгол дахь хүнсний эрх зүйн хороо (CODEX)-той хамтран ажиллах, “Зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хүүхдийн хоол тэжээлийн дутлаас сэргийлэх чиглэлээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нялхас бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдал, ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хамтран оролцох, хоол тэжээлийн төрөл, орц, найрлагад хяналт тавих, хүүхдийн хоол тэжээлийн асуудлаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах чиглэлээрх төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн тандалт судалгаа болон хүн амын дундах хэрэглээний түвшнийг судлах судалгаа зохион байгуулах, оролцох, зөвлөмж боловсруулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- Эмчилгээний хоолны болон тусгай дэглэмийн хоолны жор, цэс боловсруулах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, энэ чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах.

Орчны эрүүл мэнд тандалтын алба

Орчны эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, стратегийн баримт бичиг болон бусад бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулах, бусад салбарын хамтын ажиллагааг хангах

- Агаарын бохирдолтыг хянах, сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тандалт судалгаа хийхэд оролцох, зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах, бусад салбарын хамтын ажиллагааг уялдуулах хамтран ажиллах;
- Хөрс, усны бохирдолтыг хянах, сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичиг, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тандалт судалгаа хийхэд оролцох, зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах, энэ чиглэлээр бусад салбарын хамтын ажиллагааг уялдуулах хамтран ажиллах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, уур амьсгалын өөрчлөлт, түүний хүний биемахбодид үзүүлэх нөлөөллийн талаар тандалт судалгаа хийх, мэдээ, мэдээллээр хангах, мэдээний сан байгуулах, бусад салбарын хамтын ажиллагааг уялдуулах хамтран ажиллах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- Хотжилттой холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох үнэлэх судалгааг зохион байгуулах, оролцох, үнэлгээний дүнд үндэслэн зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах, хотжилттой холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, стандарт журмын хэрэгжилтэнд хяналт тавих, ажлын байрны эрүүл ахуйн чиглэлээр баримтлах эрүүл ахуйн стандарт боловсруулах, хэргэжилтэнд хяналт тавихад бусад байгууллагуудтай хамтран оролцох;
- Хүүхдийн байгууллагын орчин, хүүхдийн сургалтын дэглэм, нөхцөл, хүүхдийн тоглоом, хувцаст тавигдах эрүүл ахуйн стандарт боловсруулах, хэргэжилтийг зохион байгуулахад оролцох;
- Цацраг идэвхт бодис, цахилгаан соронзон долгион, дуу чимээ болон бусад физик хүчин зүйлийн нөлөөг хянах бодлогыг хэрэгжүүлэх, түүнд өртөх эрсдлийн үнэлгээг гүйцэтгэх, зөвлөмж боловсруулах;
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэргэжилтэнд хяналт тавих, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

- Ахуйн хортон шавж, мэрэгчтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр олон улсын (ДЭМБ-ын "WHOPEs") болон бусад салбар, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

Хор судлал, хордлогын тандалтын алба

Хор судлал, химийн хорт бодис, түүний хүний биемахбодид үзүүлэх нөлөөллийн чиглэлээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулах, бусад салбарын хамтын ажиллагааг хангах, хор судлал, хордлогын чиглэлээр үндэсний хэмжээнд мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлнэ.

- Химийн хорт ба аюултай бодисын хэрэглээний хяналтын бодлогыг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр бусад байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- Хөтөлбөр, төслийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- Хор судлалын хордлогын чиглэлээр нийт хүн амын дунд тандалт судалгаа хийх, тандалт судалгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- Химийн бодисын хордлогын мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээ, мэдээллээр шуурхай хангах;
- Химийн хорт бодисын бүртгэл, мэдээллийн чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;
- Хор судлал, хордлогын чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнүүдэд сургалт зохион байгуулах.

Эрүүл мэндийг дэмжих алба

Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг нийслэл, орон нутгийн түвшинд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлнэ.

- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг нийслэл, орон нутгийн түвшинд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжих нийслэлийн болон орон нутгийн санхүүжилт болон жижиг төслүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх;
- Иргэдэд эрүүл мэндийн боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах;
- Эрүүл мэндийг дэмжигч орчинг бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах;

- Хэвлэл мэдээлэл, радио телевизээр хүргэх нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн сургалт сурталчилгааны төлөвлөгөөт нэвтрүүлгийг бэлтгэн дамжуулах;
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох албан бус сургалтын хөтөлбөр боловсруулах.

Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, технологийн алба

Нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэдээний сан байгуулах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох

- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх мэдээний сангийн нэгдсэн зохицуулалт, мэдээний сангийн аюулгүй байдал, мэдээ, мэдээллийн нууцлалын асуудлыг хариуцах, мэдээллийн сүлжээ түүний тогтвортой ажиллагааг хангах;
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх холбогдох мэдээ, мэдээллээр удирдлага болон бусад байгууллага иргэдийг мэдээ, мэдээллээр хангах;
- Мэдээ, мэдээлэл, мэдээллийн технологийн чиглэлээр сургалт зохион байгуулах.

Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лаборатори

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх, бусад лабораторийг мэргэжлийн удирдлага, мэдээллээр хангах, олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдах

- Нийгмийн эрүүл мэндийн холбогдох чиглэлээр (хүний биеийн бүтцийн болон эрүүл зүйн хими, хор судлал, шим тэжээл судлал, молекул биологийн чиглэлээр) үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх;
- Нийгмийн эрүүл мэндийн бусад лабораториудыг мэргэжлийн удирдлага, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх;
- Шинжилгээнд дэвшилтэт, шинэ техник, технологи нэвтрүүлж, шинжилгээний арга заавар журам, гарын авлага боловсруулах, лабораторийн дүнг баталгаажуулах үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих;
- Нийгмийн эрүүл мэндийн лабораторийн чиглэлээр сургалтын урт ба богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Улсын хэмжээнд хэрэгжиж буй чанарын гадаад үнэлгээний тогтолцоонд оролцож, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн гадаад үнэлгээний нэгдсэн сүлжээг удирдаж, хяналт тавьж ажиллах;
- Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын нэгдсэн сүлжээнд хамрагдах.

Биотехнологийн судалгаа, үйлдвэр, инноваци, инкубатор

Анагаах ухааны биотехнологийн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, хийж гүйцэтгэх, биотехнологийн вакцин, биобэлдмэлийг үйлдвэрлэх, ханган нийлүүлэх ажлыг үндэсний түвшинд хариуцан ажиллах


- Анагаахын биотехнологи, нанотехнологийн чиглэлээр суурь судалгаа, цөм технологи, инновацийн төсөлт ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, гүйцэтгэх;
- Вакцин, биобэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний шинэ загвар боловсруулах, өнөөгийн технологийг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;
- Биоаюулгүйн асуудлаар судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан бодлогын санал, зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах;
- Урьдчилан сэргийлэх вакцин, оношлуур, тэжээлт орчин, антибиотикийн диск, цусны уурагт бэлдмэл гэх мэт дархлаажуулалтын болон эмчилгээ оношлогооны биобэлдмэлийг үйлдвэрлэх;
- Үндэсний төвийн захиралтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан аж ахуйн тооцоотой ажиллах;
- Зарим биобэлдмэлийг импортоор авах, хэрэглэгчийн захиалга, шаардлага хэрэгцээнд нийцсэн ханган нийлүүлэгчээр ажиллах;
- Биотехнологийн үйлдвэрлэлийн чиглэлээр сургалт зохион байгуулах.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

Хүний эрүүл мэнд, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн судалгааг хийх, түвшинг тогтоох, үнэлгээ өгөх судалгаа шинжилгээний ажлыг үндэсний түвшинд хийж гүйцэтгэх, зохион байгуулах, тухайн чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх бодлогын шинжлэх ухааны үндэслэл, санал, зөвлөмжийг боловсруулах, судалгааны ажлын үр дүнг нийтэд сурталчлах

- Орчны эрүүл мэндийн талаар судалгаа, шинжилгээний ажлын төсөл боловсруулах, судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх;
- Орчны эрүүл мэндийн судалгаа шинжилгээний дүнд үндэслэн шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдыг нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллээр шуурхай хангах;
- Судалгааны үр дүнг нийтэд сурталчлах;
- Орчны эрүүл мэндийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын мэдээний сан байгуулах, баяжуулах;
- Орчны эрүүл мэндийн судалгаа шинжилгээний чиглэлээр бусад салбар, олон улсын байгууллага, ижил төстэй мэргэжлийн судалгааны

- Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд, эрүүл ахуйн тулгамдсан асуудлаар судалгааны ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах судалгааны ажлын үр дүнг нийтэд сурталчлах, холбогдох арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах



Эрүүл мэндийн сайдын 2013 оны 07 сарын 31 өдрийн 146 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Шилжих хөрөнгийн жагсаалт

	Эд хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Компьютер /Dell/	4	847000-867900	3450700
2	Notebook /Dell/	1	2324682	2324682
3	Принтер /Canon, HP/	4	393500-517400	1821800
4	Канон /Sharp-5320/	1	1760500	1760500
5	Зургийн аппарат /Canon/	2	380000-609900	494950
6	Мемори карт	1	77000	77000
7	Утасны аппарат	1	52900	52900
8	Айркондейшн	1	559000	559000
9	Хөгжим /Sony/	1	49000	49000
10	Ажлын ширээ, тумбочка	4	480000	1920000
11	Ажилтны сандал	3	142000	426000
12	Хар сандал	1	57000	57000
13	Процессорын суурь	4	45000	180000
14	Ширээний хаалт	6	45000	270000
15	Дугуйтай тумбочка	3	57300-67500	187200
16	Офтальмоскоп /зөөврийн/	1	156300	156300
17	Бүсэлхийн тойрог хэмжигч	1	1320	1320
18	Сургалтын анхны тусламжын иж бүрдэл	1	22700	22700
19	Даралтын аппарат	1	18500	18500
20	Чагнуур	1	6600	6600
21	Хлоестерол хэмжигч	1	83000	83000
22	Хлоестеролын туузан онош, өндөг цоологч	25	1680	42000
23	Глюкометр /цүнх ком/	1	79000	79000
24	Глюкометрын туузан онош өндөг цоологч	50	340	17000
25	Анхны тусламжийн хайрцаг	1	120000	120000
	Нийт дүн			14177152